



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 07/154

Чингис хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 2 дугаар хуралдааны 04 тоот тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрлэн сумын 2025 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх “Ач манал өрхийн эрүүл мэндийн төвийн засвар” ХЭАХЭСЗДТГ/20250201003 дугаар бүхий ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Г.Лхагвабаатар-Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичиг: Б.Мөнхбаяр- Баянмөнх багийн Засаг дарга

Гишүүд: Т.Хосбаяр- Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын нярав
Ч.Уранцэцэг- “Ач манал” Өрхийн эрүүл мэндийн төвийн эрхлэгч

Зөвшилцсөнөөр: Б.Гантөгс- Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын хяналтын инженер

2.“Ач манал өрхийн эрүүл мэндийн төвийн засвар” ХЭАХЭСЗДТГ/20250201003 дугаар бүхий ажлыг гэрээнд заасны дагуу хүлээн авч үр дүнг танилцуулахыг комиссын дарга (Г.Лхагвабаатар)-д даалгасугай.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР